



ЦУС СЭЛБЭЛ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Ж-2-ЕР-24-01

ЦУСНЫ АЛБАНЫ МЭДЭЭЛЛИЙН  
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЖУРАМ

ЭХ ХУВЬ 1

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар:  
Ж-2-ЕР-24-01

Мэдээллийн аюулгүй байдлын журам

Хувилбар №01

Мердэж эхэлсэн  
огноо:  
2020.12.10

Өөрчлөлт  
Анхан шатны  
боловсруулалт

Өөрчлөлт  
оруулж,  
шинэчилсэн  
огноо:

Хуудас 1 / 21

Мэдээллийн инженер	технологийн	ЭШМТА-ны дарга	ЦССҮТ-ийн захирал	Ерөнхий
Ч.Далайцэрэн Г.Мөнхзаяа		Л.Өнөрбаяр	Н.Эрдэнэбаяр	
Боловсруулсан:		Хянасан:	Баталсан:	
Огноо: 2020 <i>2020.12.10</i>		Огноо: <i>2020.12.10</i>	Огноо: <i>2020.12.10</i>	
Гарын үсэг: <i>Д/Г Г.Мөнхзаяа</i>		Гарын үсэг: <i>Л.Өнөрбаяр</i>	Гарын үсэг: <i>Н.Эрдэнэбаяр</i>	



Өөрчлөлт хийгдээгүй	Албан тушаал	Гарын үсэг
Зөвшөөрсөн	2020.12.10	<i>Д/Г</i>
Хянасан	Чувьбоюла	<i>Л.Өнөрбаяр</i>
Хүчинтэй хугацаа	20.12.10 он 18 сар 10 өдөр	

Өөрчлөлт хийгдээгүй	Албан тушаал	Гарын үсэг
Зөвшөөрсөн	2020.12.10	<i>Д/Г</i>
Хянасан	Чувьбоюла	<i>Л.Өнөрбаяр</i>
Хүчинтэй хугацаа	20.12.10 он 18 сар 10 өдөр	

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар: Мэдээллийн аюулгүй байдлын журам  
Ж-2-ЕР-24-01

Хувилбар №01	Мөрдөж эхэлсэн огноо: 2020.12.10	Өөрчлөлт Анхан шатны боловсруулалт	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо:	Хуудас 2 / 21
--------------	--	--	---	---------------

## ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

Д.д	Хуудас №	Бүлэг №	Өөрчлөлт оруулсан огноо	Оруулсан өөрчлөлтийн утга	Шалтгаан	Тасгийн эрхлэгчийн гарын усэг
1			-	Анхан шатны боловсруулалт		

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар:  
ЖК-2-ЕР-24-01

Мэдээллийн аюулгүй байдлын журам

Хувилбар №01

Мөрдөж эхэлсэн  
огноо:  
2020.12.10

Өөрчлөлт  
Анхан шатны  
боловсруулалт

Өөрчлөлт  
оруулж,  
шинэчилсэн  
огноо:

Хуудас 3 / 21

# Агуулга

Д/д	Бүлэг	Хуудас
Өөрчлөлт оруулсан бүртгэл		3
1	Тодорхойлолт, товчилсон үг	5
2	Зорилго	5
3	Хамрах хүрээ	6
4	Журмаар зохицуулах үйл ажиллагаа	6
	4.1 Мэдээллийн аюулгүй байдлын зохистой хэрэглээ	6
	4.2 Мэдээлэл ангилах	8
	4.3 Нууц үгийн бодлого	9
	4.4 Цахим шуудан, дотоод мэссэнжэр ашиглах	11
	4.5 Утасгүй сүлжээ ашиглах	13
	4.6 Биет хандалтын үйл ажиллагааг зохицуулах	13
	4.7 Мэдээллийн технологийн дэд бүтцийг зохион байгуулах	15
5	Лавлах материал	16
6	Хавсралт	17
7	Холбогдох баримт бичиг	20

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба				
Баримт бичгийн дугаар:		Мэдээллийн аюулгүй байдлын журам		
Ж-2-ЕР-24-01				
Хувилбар №01	Мөрдөж эхэлсэн огноо: 2020.12.10	Өөрчлөлт Анхан шатны боловсруулалт	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо:	Хуудас 4 / 21

## **1. Тодорхойлолт, товчилсон уг:**

### **1.1. Тодорхойлолт:**

1.1.1. "Мэдээлэл" гэж цусны албанад харьяалагдах цахим хэлбэрээр эсхүл түүнээс бусад хэлбэрээр олшруулан авсан уншиж ойлгож болох бүх төрлийн мэдээллийг хэлнэ;

1.1.2. "Мэдээллийн систем"<sup>1</sup>гэж ЦССҮТ-ийн эзэмшлийн сервер, үндсэн систем, өгөгдлийн санг хэлнэ;

1.1.3. "Мэдээллийн технологи" гэж компьютер дээр суурилсан, програм хангамж болон техник хангамжийн дизайн, хөгжүүлэлт, хэрэгжүүлэлт, хангамж болон удирдлагыг судлахыг хэлнэ;

1.1.4. "Баталгаажуулалт" гэж мэдээллийг цаасан эсвэл цахим хэлбэрээр гарын үсэг зурж, бүрэн бүтэн байдал болон хариуцагч нь үгүйсгэх боломжгүй байдлаар баталгаажуулах үйл ажиллагааг хэлнэ;

1.1.5. "Дэд бүтэц" – ЦССҮТ-ийн эзэмшлийн сервер, сүлжээ, үндсэн систем, өгөгдлийн сан, компьютер, тоног төхөөрөмж (цаашид "Мэдээллийн дэд бүтэц" гэх)-ийг хэлнэ;

### **1.2. Товчилсон уг:**

1.2.1. ЦССС – Цус сэлбэлт судлалын салбар

1.2.2. ЦССҮТ - Цус сэлбэлт судлалын үндэсний төв

1.2.3. ЦСТ - Цусны салбар төв

1.2.4. МТ - Мэдээллийн технологи

1.2.5. МАБ- Мэдээлийн аюулгүй байдал

1.2.6. МАБАХ - Мэдээллийн аюулгүй байдлын ажлын хэсэг

1.2.7. ЭШМТА - Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

## **2. Зорилго**

2.1. Цус сэлбэлт судлалын салбарын мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгох, мэдээллийн дэд бүтэц, системийн найдвартай ажиллагаа, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, гаднаас болон дотоодоос учирч болох халдлага, аюул заналаас урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, хор хохирол эрсдэл учирсан тохиолдолд урьдчилан бэлтгэсэн заавар, журмын дагуу засаж сэргээх, хариу арга хэмжээ авахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.

### **2.2. ЦССҮТ-ийн нэн тэргүүнд баримтлах зарчим:**

<sup>1</sup>"Мэдээллийн систем" гэдэг нь мэдээллийг боловсруулж хөгжүүлдэг компьютер болон хүний оролцооноос бүрдсэн систем юм.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба				
Баримт бичгийн дугаар: ЖК-2-ЕР-24-01		Мэдээллийн аюулгүй байдлын журам		
Хувилбар №01	Мөрдөж эхэлсэн огноо: 2020.12.10	Өөрчлөлт Анхан шатны боловсруулалт	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо:	Хуудас 5 / 21

2.2.1. ЦССҮТ-д бүртгэлтэй 1-4 дүгээр зэрэглэлийн мэдээлэл /Цаашид “Мэдээлэл” гэх/-ийг зөвшөөрөлгүй хандалтаас хамгаалж, мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах;

2.2.2. Мэдээллийг зөвшөөрөлгүй этгээдэд санаатай болон санамсаргүй байдлаар задруулахгүй байх;

2.2.3. Мэдээллийн бүрэн бүтэн байдлыг зөвшөөрөлгүй өөрчлөлтөөс хамгаалах;

2.2.4. МАБ-тай холбоотой хууль, эрх зүйн шаардлага, зохицуулалтыг хангах;

2.2.5. Мэдээллийн системд учирч болох цахим халдлагыг илрүүлэн, таслан зогсоох, хариу арга хэмжээ авч, удирдлагад тайлагнах;

### 3. Хамрах хүрээ

3.1. ЦССҮТ болон ЦСТ-ийн бүх төрлийн мэдээлэлтэй шууд болон шууд бусаар харилцдаг эмнэлэгийн мэргэжилтэн, ажилтан, мэдээллийн технологийн мэргэжилтнууд ажил үүргээ гүйцэтгэхдээ энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

### 4. Журмаар зохицуулах үйл ажиллагаа

#### 4.1. Мэдээллийн аюулгүй байдлын зохистой хэрэглээ

4.1.1. ЦССС-д бий болж, хадгалагдаж буй бүх өгөгдөл, мэдээлэл нь ЦССҮТ-ийн өмч ба хувь хүний нууцад хамаарахгүй болно.

4.1.2. Ажилтан нь ЦССҮТ-ийн бодлого, дотоод журмын дагуу ЦССҮТ-ийн мэдээллийн дэд бүтцийн системийг гамтай, зүй зохистой ашиглах үүрэгтэй.

4.1.3. ЦССҮТ-ийн цахим хуудас, олон нийтийн сүлжээ, цахим шуудангийн хаягийг зөвхөн ЦССҮТ-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцаа холбоонд ашиглана.

4.1.4. ЦССҮТ-ийн мэдээллийн системийг дараах байдлаар ашиглахыг хориглоно:

а/ хууль бус, зүй зохисгүй байдлаар ашиглах;

б/ өөрийн нэвтрэх эрхийг бусадтай хуваалцах (гэр бүл, найз нөхөд, бусад ажиллагсад гэх мэт), санаатай ба санамсаргүй байдлаар нэвтрэх нууцлалыг задруулах;

в/ бусдын эрхээр мэдээллийн системд нэвтрэх;

г/ аливаа мэдээлэл, мэдээллийн системд зөвшөөрөлгүй өөрчлөлт хийх;

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар: Ж-2-ЕР-24-01	Мэдээллийн аюулгүй байдлын журам
--	----------------------------------

Хувилбар №01	Мөрдөж эхэлсэн огноо: 2020.12.10	Өөрчлөлт Анхан шатны боловсруулалт	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо:	Хуудас 6 / 21
--------------	--	--	---	---------------

- д/ өөрийн хандах, ашиглах эрхгүй өгөгдөл, мэдээлэлд хандах оролдлого хийх;
- е/ нууцад хамаарах баримт бичгийг хэвлэгч эсвэл хувилагчид үлдээх;
- ж/ хувийн цахим шуудангийн хаягаар байгууллагын мэдээлэл дамжуулах;
- з/ ЦССҮТ-ийн цахим шуудан, IP хаягийг ашиглан цахим халдлагын шинж чанартай аливаа үйлдэл хийхгүй байх;
- и/ цахим хуудас, нийгмийн сүлжээнд төвийг буруу танилцуулах, ЦССҮТ-ийн цахим шуудангийн хаягаар нийгмийн сүлжээнд хувийн зорилгоор нийтлэл оруулах;
- к/ садар самуун, үзэн ядалт болон зохисгүй агуулга бүхий цахим хуудсанд нэвтрэх, нийтлэл оруулах;
- л/ ЦССҮТ-ийн эзэмшлийн програм хангамж, зохиогчийн эрхээр хамгаалагдсан материалыг байршуулах, дамжуулах;
- м/ хортой код агуулсан болон агуулсан байж болзошгүй програм хангамжийг интернетээс татаж авах, ачаалах, интернетэд байршуулах;
- н/ ЦССҮТ-ийн сүлжээнд портын шалгалт (скайн) болон бусад аюулгүй байдлын шалгалт (скайн) хийх;
- о/ ажилтан хувийн цахим төхөөрөмжийг ЦССҮТ-ийн зочны сүлжээ (донор, үйлчлүүлэгчдэд зориулсан)-ээс бусад дотоод сүлжээнд холбох.

4.1.5. Дараах үйлдлийг цахим халдлага хийх оролдлого гэж үзэж, хориглоно:

- а/ ЦССҮТ-ийн мэдээллийн аюулгүй байдлын аливаа систем, програм хангамж (вирусын эсрэг програм г.м.)-ийг хаах, идэвхгүй болгох;
- б/ ЦССҮТ-ийн Мэдээллийн системд мэдээллийн аюулгүй байдлын аюул занал үүсгэх (ЦССҮТ-ийн аливаа мэдээлэл, сервер, системд зөвшөөрөлгүйгээр хандах, сүлжээний урсгалыг тандах, хорлон сүйтгэх зорилгоор ICMP пакетын бөөгнөрөл үүсгэх, үйлчилгээг бусниулах, буфер дүүргэх, замчлалын мэдээллийг хуурамчаар үйлдэх зэрэг үйлдлүүд багтана.);
- в/ зохиогчийн эрхийн хуулийг зөрчих (зохиогчийн эрхээр хамгаалагдсан зураг, дуу, дурс, програм хангамжийг хууль бусаар хуулбарлах, дамжуулах үйлдлүүд хамаарна.);
- г/ санаатайгаар хортой код оруулах (вирус, өт (worms), Троян хортой код (Trojan horses), цахим шууданг ачаалалд оруулах (email bombs), тагнан турших

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба				
Баримт бичгийн дугаар: ЖК-2-ЕР-24-01		Мэдээллийн аюулгүй байдлын журам		
Хувилбар №01	Мөрдөж эхэлсэн огноо: 2020.12.10	Өөрчлөлт Анхан шатны боловсруулалт	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо:	Хуудас 7 / 21

Баримт бичгийн дугаар: ЖК-2-ЕР-24-01				Мэдээллийн аюулгүй байдлын журам
Хувилбар №01	Мөрдөж эхэлсэн огноо: 2020.12.10	Өөрчлөлт Анхан шатны боловсруулалт	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо:	Хуудас 7 / 21

(spyware), зар сурталчилгааны (adware), болон компьютерын товчлуурыг тандах (keyloggers) програм хангамж зэрэг багтана.);

4.1.6. ажилтан нь өөрт нь хариуцуулан олгосон компьютер, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй ба эдгээрийг хулгайд алдсан тохиолдолд шууд удирдлагад яаралтай мэдэгдэнэ.

4.1.7. ажилтан нууцад хамаарах мэдээллийг хадгалж буй суурин ба зөөврийн компьютер, таблет, ухаалаг төхөөрөмж, ажлын ширээг өөрийн биеэр ашиглаагүй тохиолдолд түгжих эсвэл нууц үгээр хамгаалагдсан дэлгэц амраах горимоор хамгаална.

4.1.8. ажилтан нь ЦССҮТ-ийн нууцад хамаарах мэдээллийг хадгалж буй, ЦССҮТ-өөс олгогдсон зөөврийн төхөөрөмжийн хатуу дискийг ЦССҮТ-ийн МТ-ийн инженерт хандан, шифрлүүлнэ.

4.1.9. ажилтан нь ЦССҮТ-ийн эзэмшлийн мэдээллийг ЦССҮТ-ийн байнгын хяналтанд байлгах үүргийг хүлээнэ.

## 4.2. Мэдээллийн нууцлал, ангилал

4.2.1. ЦССҮТ-ийн мэдээллийг доор тодорхойлсон мэдээлэл ангилах зэрэглэлийн дагуу ангилна.

4.2.2. Ангиллын дараах 4 зэрэглэл байна:

а/ **хориотой** /1 дүгээр зэрэглэл/- хууль, эрх зүйн актын хүрээнд ЦССҮТ-ээс чанд нууцалж, хамгаалах үүрэгтэй мэдээллийг хамруулна. (Донорын мэдээлэл, лабораторийн шинжилгээний хариу, цус цусан бүтээгдэхүүний мэдээлэл болон хувь хүнийг таних мэдээлэл багтана.);

б/ **хязгаарлагдмал** /2 дугаар зэрэглэл/- зөвшөөрөлгүй этгээдэд задруулсан тохиолдолд хувь хүний болон ЦССҮТ-ийн нууцад халдах, ЦССҮТ-ийн үйл ажиллагаанд сэргэөр нөлөөлж болохуйц мэдээллийг хамруулна. (ЦССҮТ-ийн эзэмшлийн болон оюуны өмчид хамаарах мэдээлэл);

в/ **дотоод** /3 дугаар зэрэглэл/- олон нийтэд ил болгоход зориулагдаагүй, ЦССҮТ-ийн мэдээллийг хамруулна. Дотоод мэдээллийг удирдлагын зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглоно;

г/ **нээлттэй** /4 дүгээр зэрэглэл/- олон нийтэд ил болсон нөхцөлд байгууллага, хувь хүний нууцад сэргэөр нөлөөлөхгүй аливаа мэдээллийг хамруулна.

4.2.3 Мэдээллийн ангилал болон ангилал тус бүрт хамаарах мэдээллийг дамжуулах, устгахдаа Хавсралт 1-т заасан зарчмыг баримтална.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар: Мэдээллийн аюулгүй байдлын журам  
Ж-2-ЕР-24-01

Хувилбар №01	Мөрдөж эхэлсэн огноо: 2020.12.10	Өөрчлөлт Анхан шатны боловсруулалт	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо:	Хуудас 8 / 21
--------------	--	--	---	---------------

4.2.4 ЦССҮТ-ийн мэдээллэлтэй харьцаж буй бүх ажилтан, гуравдагч этгээд нь ЦССҮТ-тэй холбоотой мэдээлэлд хамаарах аюулгүй байдлын зохих хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

4.2.5 Олон нийтэд нээлттэй мэдээллээс бусад төрлийн мэдээллэлтэй харьцах шаардлагатай гуравдагч этгээдээр нууцын баталгааны хуудаст гарын үсэг зуруулж, баталгаажуулна.

4.2.6 Хэрэв гуравдагч этгээд ЦССҮТ-ийн нэрийн өмнөөс мэдээллийг хариуцсан тохиолдолд, мэдээллийг хуваалцахын өмнө энэ журамтай танилцуулан, гарын үсгээр баталгаажуулах шаардлагатай.

4.2.7 Аливаа мэдээлэл нь мэдээллийн ангиллын аль нэг зэрэглэлд заавал хамаарна.

4.2.8 Ялгаатай зэрэглэл бүхий олон төрлийн мэдээлэл нэгдсэн тохиолдолд тэдгээрийн хамгийн өндөр түвшинтэй мэдээллийн ангилалд хамруулна.

4.2.9 Мэдээллийг буруу ангилалд хамааруулсан, эсвэл мэдээлэл ангилах журмын дагуу удирдан зохион байгуулаагүй нөхцөлд тухайн мэдээллийг хариуцсан алба, тасгийн удирдлагад яаралтай мэдэгдэх шаардлагатай.

4.2.10 Мэдээллийг удирдахдаа дараах ерөнхий зарчмыг баримтална:

а/ ЦССҮТ-ийн эзэмшлийн бүх хэлбэрээр оршин буй мэдээлэл үнэ цэнэтэй байх бүх цаг үед ЦССҮТ-ийн мэдээллийн нууцлалтыг хадгалах;

б/ мэдээллийг зөвхөн эрх бүхий этгээдтэй хуваалцах;

в/ мэдээллийг зөвхөн ЦССҮТ-ийн эзэмшлийн компьютер, тоног төхөөрөмж дээр хадгалах;

г/ мэдээллийн нууцлал алдагдсан болон хулгайлагдсан тохиолдолд Эрдэм шинжилгээ мэдээллийн технологийн албанад яаралтай мэдэгдэх.

4.2.11 Хориотой ангиллын мэдээлэлд хандах эрхийг ЦССҮТ-ийн Төрийн болон албаны нууц хариуцсан ажилтанд хүсэлт гаргаж, ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын зөвшөөрлөөр олгоно.

4.2.12 Хориотой болон хязгаарлагдмал ангилалд хамаарах мэдээллийг агуулсан цаасан бичиг баримтыг дахин сэргээгдэхгүйгээр шатаах эсвэл цаас устгагчаар жижиглэн устгах шаардлагатай.

4.2.13 Хязгаарлагдмал ангиллын мэдээлэлд хандах эрхийг холбогдох алба, тасгийн удирдлагын зөвшөөрлөөр олгоно.

4.2.14 Хориотой болон хязгаарлагдмал ангилалд хамаарах цахим хэлбэрийн мэдээллийг зөвхөн ЦССҮТ-ийн эзэмшлийн компьютер, тоног төхөөрөмж дээр боловсруулан, хадгална.

4.2.15 Хориотой болон хязгаарлагдмал ангиллын биет мэдээлэлд зохих тэмдэглэгээг хийж, ЦССҮТ-ийн байранд цроожтой орчинд хадгална.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар:  
ЖК-2-ЕР-24-01

Мэдээллийн аюулгүй байдлын журам

Хувилбар №01

Мөрдөж эхэлсэн  
огноо:  
2020.12.10

Өөрчлөлт  
Анхан шатны  
боловсруулалт

Өөрчлөлт  
оруулж,  
шинэчилсэн  
огноо:

Хуудас 9 / 21

### 4.3 Нууц үгийн бодлого

4.3.1 Мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал алдагдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор компьютер, мэдээллийн системд нууц үгийг ашиглана

4.3.2 Нууц үгийн бодлого нь ЦССҮТ-ийн эзэмшлийн аливаа системд нэвтрэх эрхтэй (нууц үгээр нэвтэрч ордог бүх төрлийн систем, програм хангамж, компьютер, тоног төхөөрөмж хамаарна), ЦССҮТ-ийн эзэмшлийн мэдээллийг боловсруулж, дамжуулж, хадгалдаг нийт ажилтанд хамаарна.

4.3.3 Мэдээллийн технологийн инженер нь тодорхойлсон дарааллын дагуу хандалтын эрхийг олгоно.

4.3.4 Нууц үгээр алдсан, эсхүл алдагдаж болзошгүй нөхцөл байдал үүссэн даруй нууц үгийг эзэмшигч нь Мэдээллийн технологийн инженер, эсхүл МАБАХ-ийн гишүүнд шуурхай мэдэгдэх үүрэгтэй.

4.3.5 Ажилтан бүр өөрийн хандах эрхээр хийгдсэн аливаа үйлдэлд хариуцлага хүлээнэ.

4.3.6 Ажил, үүргийн хэрэгцээ шаардлагаар ЦССҮТ-ийн мэдээлэлд хандах шаардлагатай ажилтанд Мэдээллийн технологийн инженер зохих системд хандах хэрэглэгчийн нэр, нууц үгийг олгоно.

4.3.7 Ажилтан бүр ЦССҮТ-өөс олгосон өөрийн нууц үгийн нууцлалыг хангах, хамгаалах үүргийг хүлээнэ.

4.3.8 Нууц үг зохиохдоо доорх зөвлөмжийг дагана:

а/ системд нэвтрэх хэрэглэгчийн нэр болон түүний хэсгээс ашиглахгүй байх;

б/ 8 (найм) ба түүнээс дээш тэмдэгт хэрэглэх;

г/ үсэг, тоо, тусгай тэмдэгтийн хослолыг хэрэглэх;

д/ хоорондоо үл хамааралтай хоёроос гурван богино үгийг хэрэглэх.

Зөв	Буруу
TulgaaНаран4020@ Тайлбар: Хоёроос дээш үгээс бүтсэн өгүүлбэр, том, жижиг үсэг, тоо,	Tulgaa0420 Тайлбар: Өөрийн болон ойр дотны хүмүүсийн нэр, утасны дугаар, төрсөн

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар: Мэдээллийн аюулгүй байдлын журам  
Ж-2-ЕР-24-01

Хувилбар №01	Мөрдөж эхэлсэн огноо: 2020.12.10	Өөрчлөлт Анхан шатны боловсруулалт	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо:	Хуудас 10 / 21
--------------	--	--	---	----------------

## 4.3.9 Нууц үгийг ашиглахдаа дараах зөвлөмжийг дагана:

- а/ өөрийн нууц үгийг бусдад хэлэхгүй байх;
- б/ тоног төхөөрөмжийг дагалдан ирдэг үйлдвэрийн анхны нууц үгийг хэрэглэхгүй байх;
- в/ нууц үгээ хийж байх үед хэн нэгэн анзаарах, ашиглахаас сэргийлэх;
- г/ нүдэнд харагдахуйц газарт нууц үгийг бичихгүй байх;
- д/ нууц үгээ 6 сар тутам сольж байх;
- е/ хуучин нууц үгийг дахин ашиглахгүй байх;
- ж/ ажлын байрнаас холдсон үед ажлын ширээ аюулгүй байгаа эсэхийг шалгаж байх. Ажлын ширээнээс холдохдоо компьютерын дэлгэцийг унтраах, түгжих, нууц үгээр хамгаалагдсан дэлгэц амраагч ашиглах.

## 4.3.10 Нууц үг олгох, хадгалах, удирдах үйл ажиллагаанд баримтлах бодлого:

- а/ ажилтан нь ЦССҮТ-ийн үйл ажиллагаанд хэрэглэж буй мэдээллийн систем, мэйл, програм хангамжид нэвтрэх нэр, нууц үгийг шинээр авах, солиулах хүсэлтээ маягтын дагуу ЭШМТА-ны даргаас зөвшөөрөл авч мэдээллийн технологийн ажилтнаар нээлгүүлнэ; /Маягт хавсралт 2/
- б/ ажилтан нь олгосон нууц үгийг анхны нэвтрэлтээр солих шаардлагатай;
- в/ шаардлагатай нөхцөлд гэрээт ажилтан, бүтээгдэхүүн нийлүүлэгчдэд түр хандалтын эрхийг тодорхой хугацаагаар олгож болох ба эрхийг ашиглах хугацаа дуусмагц эрхийг хаана;
- г/ нууц үгийг дамжуулах, хадгалахдаа шифрлэлтийн алгоритмыг ашиглан үл уншигдах хэлбэрт хувиргана;
- д/ бүлгийн буюу дундын нэвтрэх эрх, нууц үгийг ашиглахыг хориглоно;
- е/ системд нэвтрэх З удаагийн амжилтгүй оролдлогын дараа хэрэглэгчийн эрхийг түгжинэ;
- ж/ үндсэн систем ба тоног төхөөрөмжийн терминалд 15 минутын турш идэвхгүй байсан тохиолдолд тухайн терминал идэвхгүй болох ба терминалыг дахин идэвхжүүлэхийн тулд ажилтан нь өөрийн нууц үгийг дахин оруулах шаардлагатай;

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар:  
ЖК-2-ЕР-24-01

Мэдээллийн аюулгүй байдлын журам

Хувилбар №01	Мөрдөж эхэлсэн огноо: 2020.12.10	Өөрчлөлт Анхан шатны боловсруулалт	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо:	Хуудас 11 / 21
--------------	--	--	---	----------------

#### 4.4 Цахим шуудан, дотоод мэссэнжэр ашиглах

4.4.1 ЦССҮТ-өөс олгосон цахим шуудан, дотоод мэссэнжэрийн эрхийг эзэмшиж буй нийт ажилтанд хамаарна.

4.4.2 Ажлын хэрэгцээ шаардлага бүхий ажилтанд ЦССҮТ-ийн цахим шууданг нээж, нууц үгийн бодлогын дагуу нууц үгийг олгох ба ЦССҮТ-ийн үйл ажиллагаанд оролцохдоо тус цахим шуудангийн хаягийг ашиглана.

4.4.3 Ажилтны хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон, цуцлагдсан тохиолдолд тус ажилтны цахим шуудангийн хаягт байрших бүх цахим мэдээллийг илгээгч, хүлээн авагч хэн байхаас үл хамааран татаж авах, дамжуулан илгээх, хэвлэх үйлдлийг ЦССҮТ-өөс хаана.

4.4.4 Ажилтан цахим шуудан илгээхдээ и-мэйл хүрэх ёстой гэж үзсэн хүнийг болон өөрийн харьяалагдах алба, тасгийн шууд удирдлагын цахим шуудангийн хаяг руу давхар илгээх (СС хийх) шаардлагатай.

4.4.5 Цахим шуудан илгээхдээ шуудан хүлээн авагчийг төөрөгдүүлэхээс сэргийлэн, цахим шуудангийн “Гарчиг” буюу “Subject” хэсэгт тухайн и-мэйл юуны тухай яригдаж, хэлэлцэгдэж байгаа тухай товч, тодорхой бичиж, илгээнэ.

4.4.6 ЦССҮТ-ийн цахим шуудангийн хаягийг дараах байдлаар ашиглахыг хориглоно:

а/ хууль бус, найдваргүй, нэр хүнд муутай, сэжигтэй цахим хуудас, үйлчилгээнд бүртгүүлэх;

б/ улс төрийн болон шашны агуулгатай, хэл амаар доромжилсон, ялгаварлан гадуурхсан утга агуулга бүхий зурvas илгээх;

в/ садар самуун сурталчилсан, гутаан доромжилсон, гүтгэсэн, арьс өнгөөр ялгаварласан агуулга бүхий зурvas дамжуулах;

г/ бусдын цахим шуудан руу санаатайгаар спам илгээх (зар сурталчилгаа эсвэл хортой код тараах зорилгоор интернет сүлжээгээр дамжуулан олон тооны хэрэглэгчид руу хүсээгүй цахим шуудан илгээх);

д/ цахим шуудан хүлээн авагчийг төөрөгдүүлэх зорилгоор өөрийн нэрийг нуун дарагдуулах, гүйвуулах, хэрэглэгчийг таних мэдээллийг солих;

е/ спам болон сүлжээний бизнесүүдийн и-мэйлийг дамжуулахгүй, тодорхойгүй, танъж мэдэхгүй эзнээс ирсэн и-мэйл болон хавсаргасан файлуудыг нээж үзэхгүй байх;

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар: Ж-2-ЕР-24-01	Мэдээллийн аюулгүй байдлын журам
--	----------------------------------

Хувилбар №01	Мөрдөж эхэлсэн огноо: 2020.12.10	Өөрчлөлт Анхан шатны боловсруулалт	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо:	Хуудас 12 / 21
--------------	--	--	---	----------------

ж/ Хориотой зэрэглэлд хамаарах материал болон мэдээллийг и-  
мэйлээр илгээх;

з/ ЦССҮТ-ийн үйл ажиллагаатай хамааралгүй байдлаар, хувийн ашиг  
сонирхлоор цахим шууданг ашиглах;

и/ хувийн зорилгоор цахим шууданг гадаад хаяг руу хуулах, автоматаар  
дамжуулахаар (forward) тохируулах;

к/ хууль бус, ёс зүйд үл нийцэх бусад үйлдлүүд.

4.4.7 ЦССҮТ-ийн цахим шууданг ашиглахдаа аюулгүй байдлын дараах  
арга хэмжээг мөрдөнө:

а/ цахим шуудангаар сэжигтэй хавсралт ирсэн тохиолдолд Мэдээллийн  
технологийн инженерт утсаар эсвэл биечлэн яаралтай мэдэгдэх ба бусад руу  
дамжуулах, хуулахыг хориглоно.

б/ ажилтан нь ЦССҮТ-өөс олгосон компьютер дээр ажиллаж буй  
вирусын эсрэг програм хангамж, аюулгүй байдлын хяналтын бусад програм  
хангамжийг байнга идэвхтэй байлгана.

в/ үл таних этгээдээс ирсэн цахим шууданг сэжигтэй гэж үзэн, цахим  
шуудангийн хаяг, нэр нь үнэн зөв, албан ёсны болохыг шалгана.

г/ цахим шуудангаар илгээсэн хавсралт, холбоосын агуулгыг  
хангалттай тайлбарлаагүй нөхцөлд хавсралтыг нээх, холбоос дээр дараахаас  
зайлсхийнэ.

д/ дүрмийн алдаа, том үсэг, олон тооны тусгай тэмдэгүүд агуулсан байх  
нь сэжигтэй цахим шууданд тооцогдох тул эдгээр зөрчлийг шалгана.

4.4.8 ЦССҮТ-ийн цахим шууданг ашиглан зурvas илгээхдээ Хавсралт 3-  
т хавсаргасан Гарын үсэг болон Тайлбарыг зурваст агуулна.

4.4.9 Ажилтанд олгосон цахим шуудангийн хаяг, дотоод мэссэнжэрийн  
нэвтрэх эрх нь ЦССҮТ-ийн өмч болно. ЦССҮТ-ийн дотоод месенжерийн системээс  
илгээсэн, хүлээн авсан, түүнд хадгалагдаж буй бүх зурvas нь ажилтны өмч биш  
бөгөөд ЦССҮТ-ийн эзэмшилд хамаарна.

4.4.10 ЦССҮТ нь ажилтны илгээсэн, хүлээн авсан бүх зурвасыг  
шаардлагатай нөхцөлд харах, хянах, ил болгох, зогсоох эрхтэй.

4.4.11 Ажилтан нь зөвхөн байгууллагад ажиллах хугацаандаа эдгээр  
нэвтрэх эрхийг ашиглах эрхтэй.

## 4.5 Утасгүй сүлжээ ашиглах

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар:  
ЖК-2-ЕР-24-01

Мэдээллийн аюулгүй байдлын журам

Хувилбар №01

Мөрдэж эхэлсэн  
огноо:  
2020.12.10

Өөрчлөлт  
Анхан шатны  
боловсруулалт

Өөрчлөлт  
оруулж,  
шинэчилсэн  
огноо:

Хуудас 13 / 21

4.5.1 ЦССҮТ-ийн байранд ашиглаж буй, ЦССҮТ-ийн сүлжээнд холбогдон, тус ЦССҮТ-ийн мэдээлэлд хандаж байгаа утасгүй сүлжээний дэд бүтцийн бүх төхөөрөмжүүд дараах шаардлагыг хангасан байна:

а/ утасгүй сүлжээнд шифрлэлтийн WPA2 протоколыг ашиглах ба уг протоколыг дэмждэг тоног төхөөрөмжийг ашиглах;

б/ утасгүй сүлжээний төхөөрөмжийн үйлдвэрийн анхны тохиргоо болох шифрлэлтийн түлхүүр (encryption keys), SNMP нууц үг (SNMP passwords), дундын түлхүүр (pre-shared keys PSK), нэвтрэх нууц түлхүүр (passphrases) зэргийг ЦССҮТ-ийн “Нууц үгийн бодлого”-ын дагуу заавал сольж, шинэчилэх.

4.5.2 Утасгүй сүлжээний аливаа төхөөрөмжийг зөвшөөрөгдсөн төрөл, загварын дагуу зөвхөн баталгаат борлуулагчаас худалдан авна.

4.5.3 Утасгүй сүлжээний аливаа тоног төхөөрөмжийг суурилуулж, ашиглалтад оруулахдаа ЭШМТА-ны даргаас албан ёсны зөвшөөрлийг урьдчилан авсан байна.

4.5.4 Утасгүй сүлжээний бүх тоног төхөөрөмжийг зөвшөөрөгдсөн байршилд, зориулалтын дагуу ашиглана.

4.5.5 ЦССҮТ-ийн утасгүй сүлжээ нь нууц үгээр хамгаалагдсан байна.

4.5.6 Утасгүй сүлжээнд нэвтрэх нууц үгийг 6 (зургаан) сар тутам солино.

4.5.7 ЦССҮТ-ийн байранд гадны этгээд биетээр нэвтэрсэн тохиолдолд, түр хэрэглэгчдэд зориулан логикоор тусгаарласан “Зочин”-ы сүлжээг үүсгэсэн байх шаардлагатай.

## 4.6 Биет хандалтын үйл ажиллагааг зохицуулах

4.6.1 ЦССҮТ нь мэдээлэл, түүнийг боловсруулах, дамжуулах, хадгалах төхөөрөмж, орчин, бүсийг хамгаалах зорилгоор аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэнэ.

4.6.2 Серверийн өрөөнд зөвшөөрөгдсөн ажилтан нэвтрэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цоож, түлхүүр гэх мэт нэвтрэх хяналтыг зохих түвшинд тавьж, хамгаалалтыг хэрэгжүүлнэ.

4.6.3 Серверийн өрөөнд зочин биет хандалт хийсэн нөхцөлд түүний нэвтэрсэн бүртгэлийг хөтөлж, архивлан хадгална.

4.6.4 Серверийн өрөөг хянах зорилгоор хяналтын камер болон нэвтрэх үйл ажиллагаанд хяналтын хэрэгслийг (access control) ашиглана. Камер ба бусад хяналтын хэрэгслээс гарч буй өгөгдлийг дор хаяж 3 (гурван) сарын турш хадгална.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар:  
ЖК-2-ЕР-24-01

Мэдээллийн аюулгүй байдлын журам

Хувилбар №01	Мөрдөж эхэлсэн огноо: 2020.12.10	Өөрчлөлт Анхан шатны боловсруулалт	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо:	Хуудас 14 / 21
--------------	--	--	---	----------------

4.6.5 ЦССҮТ нь гал, ус, газар хөдлөлт, дэлбэрэлт, бослого, үймээн самуун, хүний болон байгалийн гаралтай бусад төрлийн гамшгаас үүдэн гарах аюулын эсрэг биет хамгаалалтыг хэрэгжүүлнэ.

4.6.6 Хяналтын камер, нэвтрэх хяналтын (access control) хэрэгсэл, сүлжээний үүр, утасгүй сүлжээ тараагч төхөөрөмж болон бусад эмзэг төхөөрөмжид хандах биет хандалт зөвхөн зөвшөөрөлтэй ажилтнаар хязгаарлагдана.

4.6.7 Үйлчлүүлэгчийн мэдээллийг боловсруулж буй сүлжээнд зөвшөөрөлгүй хандалт хийхийг хориглоно.

4.6.8 Мэдээлэлд хандаж, боловсруулалт хийхэд ашиглаж буй төхөөрөмжийг орчны аюул, занал, зөвшөөрөлгүй нэвтрэлтээс урьдчилан сэргийлж, хамгаална.

4.6.9 Уг төхөөрөмжийг цахилгааны тасалдал болон цахилгаан хэрэгслийн гэмтлээс үүсэх аливаа доголдлоос хамгаална. Мэдээлэл дамжуулж буй цахилгааны болон сүлжээний кабель, шугамыг саатал, гэмтлээс хамгаална. Саатал гарсан тохиолдолд яаралтай саатал гэмтлийг арилгах арга хэмжээ авна.

4.6.10 Мэдээллийг агуулж буй бүх төрлийн хадгалах төхөөрөмжийг бусдад дамжуулахын өмнө ЦССҮТ-ийн мэдээлэл, лиценэтэй програм хангамжийг бүрэн устгасан эсэхийг шалгана.

4.6.11 Хориотой мэдээлэл агуулсан цахим хэрэгслийг бусдад дамжуулахаас өмнө дахин сэргээгдэхгүйгээр устгах эсвэл биетээр эvdэн сүйтгэх арга хэмжээ авна.

4.6.12 Бүх төрлийн хадгалах хэрэгслийг алдах, хуулбарлахаас хамгаална. (Компьютер, зөөврийн цахим төхөөрөмж, цаасан баримт бичиг, факс гэх мэт.)

4.6.13 Хориотой мэдээлэл агуулж буй аливаа тоног төхөөрөмж, хадгалах хэрэгсэл, цаасан суурьтай бичиг баримтыг бичгээр өгсөн зөвшөөрөлгүй тохиолдолд ЦССҮТ-ийн байрнаас авч гарахыг хориглоно.

#### 4.7 Мэдээллийн технологийн дэд бүтцийг зохион байгуулах

4.7.1 Мэдээллийн технологийн инженер нь ЦССҮТ-ийн МТ-ийн дэд бүтцийн аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих, өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулах үүрэгтэй.

4.7.2 Төв нь өөрийн эзэмшлийн сервер, сүлжээ, үндсэн систем, өгөгдлийн сан, компьютер, тоног төхөөрөмж (цаашид Мэдээллийн дэд бүтэц гэх)-ийг зөвшөөрөлгүй хандалтаас хамгаалах, түүнээс үүдэн мэдээллийн хөрөнгөд гарч болох эрсдэлээс хамгаалахыг зорино.

4.7.3 Мэдээллийн системийн эзэмшигч нь Мэдээллийн технологийн инженер байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар:  
Ж-2-ЕР-24-01

Мэдээллийн аюулгүй байдлын журам

Хувилбар №01

Мөрдөж эхэлсэн  
огноо:  
2020.12.10

Өөрчлөлт  
Анхан шатны  
боловсруулалт

Өөрчлөлт  
оруулж,  
шинчилсэн  
огноо:

Хуудас 15 / 21

#### 4.7.4 Мэдээллийн системд хандахдаа дараах зарчмыг мөрднө:

- а/ бүх Мэдээллийн системд зөвхөн зөвшөөрөлтэй ажилтан хандана;
- б/ дэд бүтцэд хандах эрх олгоходо дараах зарчмыг баримтална:
  - Зайлшгүй шаардлагатай эрх - ажилтанд зөвхөн оногдсон үүрэг, хариуцлагаа биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай системд хандах эрхийг олгоно.
  - Хамгийн бага хандах эрх -ажилтанд зөвхөн оногдсон үүрэг, хариуцлагаа биелүүлэхэд нь шаардлагатай хамгийн бага эрхийг олгоно.

4.7.5 Мэдээллийн системд хандах эрх аваходаа өөрийн харьяалагдах тасгийн эрхлэгчид Хавсралт 4-т заасан маягтын дагуу хүсэлт гаргана. ЭШМТА-ны даргад тасгийн эрхлэгчээс бичгээр ирүүлсэн хүсэлтэд үндэслэн МТ-ийн инженер нь зохих зөвшөөрлийг олгоно.

4.7.6 МТ-ийн инженер нь хориотой зэрэглэлийн мэдээлэл агуулсан Мэдээллийн системд бүртгэлтэй хэрэглэгчдийн жагсаалтыг улирал тутамд хянаж, баталгаажуулна.

4.7.7 Мэдээллийн системд хандаж буй хэрэглэгчдийн хандсан бүртгэлийг төвлөрсөн лог серверт гурван сараас багагүй хугацаатай хадгална.

4.7.8 Байгууллагын тоног төхөөрөмжид зөөврийн хадгалах хэрэгсэл (USB флэш диск) холбохыг хориглоно.

4.7.9 Зөөврийн хэрэгсэл ашиглах ажил хэргийн зайлшгүй шаардлагатай нөхцөлд Хавсралт 5-д заасан маягтын дагуу ЭШМТА-ны даргаас бичгээр зөвшөөрөл авна. МТ-ийн инженер нь зөөврийн хэрэгсэл ашиглах эрхийг бичгээр ирүүлсэн зөвшөөрөлд үндэслэн тухайн ажилтны компьютерт нээж өгнө.

4.7.10 Мэдээллийн системийн хэвийн ажиллагааг хангахдаа дараах зарчмыг баримтална:

а/ мэдээллийн системийн Үндсэн системийн хэвийн ажиллагааг хангахдаа Хавсралт 6-д заасан шалгах хуудсын дагуу баримтжуулна.

б/ ЭШМТА-ны дарга нь долоо хоног тутам шалгах хуудсыг хянаж, гарын үсэг зурж, архивлан хадгална.

в/ мэдээллийн технологийн инженер нь ЦССҮТ-ийн мэдээллийг боловсруулах, хадгалах, дамжуулах үйл ажиллагаанд оролцож буй компьютер, тоног төхөөрөмж, Мэдээллийн системд аюулгүй байдлын шинэчлэлийг тогтмол хийж, бүртгэлийг улирал тутам шалгана.

4.7.11 Сүлжээний дэд бүтцэд дараах шаардлагыг дагаж мөрднө:

а/ ЦССҮТ-ийн бүх дэд бүтцийг гадаад сүлжээнээс хамгаалалтын төхөөрөмж (файрвол)-өөр хамгаална.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар: Мэдээллийн аюулгүй байдлын журам

ЖК-2-ЕР-24-01

Хувилбар №01

Мөрдөж эхэлсэн  
огноо:  
2020.12.10

Өөрчлөлт  
Анхан шатны  
боловсруулалт

Өөрчлөлт  
оруулж,  
шинэчилсэн  
огноо:

Хуудас 16 / 21

б/ сүлжээний топологийн бүдүүвч зургийг Хавсралт 7-д хавсаргасан ба сүлжээнд аливаа өөрчлөлт хийх тохиолдолд тогтмол шинэчилнэ.

в/ зөвшөөрөгдсөн бүх сервис болон портууд дээр тэдгээрийг нээх шаардлагыг агуулсан баримтжуулалт байх шаардлагатай.

г/ ЦССҮТ-ийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор сүлжээний кабель шугамд тэмдэглэгээ хийсэн байна.

## 5. ЛАВЛАХ МАТЕРИАЛ

5.1. Эрүүл мэндийн сайдын 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/396 тоот тушаал

5.2. Монгол улсын стандарт MNS 17799.2007

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар:  
ЖК-2-ЕР-24-01

Мэдээллийн аюулгүй байдлын журам

Хувилбар №01

Мөрдөж эхэлсэн  
огноо:  
2020.12.10

Өөрчлөлт  
Анхан шатны  
боловсруулалт

Өөрчлөлт  
оруулж,  
шинэчилсэн  
огноо:

Хуудас 17 / 21

## 6. ХАВСРАЛТ

## Хавсралт 1. Мэдээллийн ангилалын маягт

Өөрчлөлтийн түүх:

Д/д	Өөрчлөлт		Өөрчлөлт хийсэн		Огноо
1	Анхан шатны боловсруулалт				2020.08.04
Д/д	Мэдээллийн ангилаал	Мэдээлэл	Мэдээллийн хэлбэр	Дамжуулах	Устгах
1	Нууц	Донорын мэдээлэл Лабораторийн шинжилгээний хариу Цус цусан бүтээгдэхүүний мэдээлэл Хувь хүнийг таних мэдээлэл	Цаасан Цахим	Дугтуйнд хийж, нууцын дардас дарна. ЦССҮТ-ийн цахим шуудан, дотоод сүлжээнд шифрлэх эсвэл нууц үгээр түгжиж дамжуулна. Баримт бичгийн баруун дээд хэсэгт "НУУЦ" тэмдэглэгээг тавина.	Цаас устгагчаар устгана. Сэргэх боломжгүйгээр устгана.
2	Хязгаарлагд мал	Гэрээ Ажилтны цалингийн цэс, хувийн хэрэг Санхүүгийн төлөвлөгөө, тайлан Захирлын тушаал Мэдээллийн системийн мэдээлэл Хурлын тэмдэглэл (агуулгаас хамаарна)	Цаасан Цахим	Дугтуйнд хийнэ. ЦССҮТ-ийн цахим шуудан, дотоод сүлжээгээр дамжуулж, ЦССҮТ-ийн эзэмшилийн тоног төхөөрөмж дээр хадгална.	Цаас устгагчаар устгана. Сэргэх боломжгүйгээр устгана.
3	Дотоод	Ажлын байрны тодорхойлолт Ажлын төлөвлөгөө, тайлан Хурлын тэмдэглэл (агуулгаас хамаарна) Дотоод журам МАБ-ын журам	Цаасан Цахим	Хязгаарлалт байхгүй ЦССҮТ-ийн цахим шуудан, дотоод сүлжээгээр дамжуулж, ЦССҮТ-ийн эзэмшилийн тоног төхөөрөмж дээр хадгална.	Цаас устгагчаар устгана. Хязгаарлалт байхгүй
4	Нээлттэй	Иргэдэд зориулан гаргасан зөвлөмж, зар сурталчилгээ Ажлын байрны зар ЦССҮТ-ийн танилцуулга, вэб сайт	Цаасан Цахим	Хязгаарлалт байхгүй Хязгаарлалт байхгүй	Хязгаарлалт байхгүй Хязгаарлалт байхгүй

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба

Баримт бичгийн дугаар:  
ЖК-2-ЕР-24-01

Мэдээллийн аюулгүй байдлын журам

Хувилбар №01

Мөрдөж эхэлсэн огноо:  
2020.12.10Өөрчлөлт  
Анхан шатны боловсруулалтӨөрчлөлт  
оруулж,  
шинэчилсэн огноо:

Хуудас 18 / 21

## Хавсралт 2. Нууц үг солих маягт

ЦСС салбарын үйл ажиллагаанд хэрэглэж буй мэдээллийн систем, мэйл, програм хангамжид нэвтрэх нэр, нууц үг солих маягт

№	Системийн нэр	Алба, тасгийн нэр	Нууц үг авах ажилтны албан тушаал	Овог, нэр	Шалтгаан
1					
2					
3					

Хүсэлт гаргасан .....  
 Хянасан .....  
 Зөвшөөрсөн .....  
 Эрх олгосон .....

## Мэдээллийн системд хандах эрхийн нууц үг өөрчлүүлэх маягт

Тасгийн нэр: .....  
 Албан тушаал: .....  
 Овог, Нэр: .....  
 Системийн нэр: .....  
 Нууц үг солих шалтгаан: .....  
 Хүсэлт гаргасан огноо: .....

Хүсэлт гаргасан .....  
 Хянасан .....  
 Зөвшөөрсөн .....  
 Эрх олгосон .....

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба  
 Баримт бичгийн дугаар: ..... Мэдээллийн аюулгүй байдлын журам

ЖК-2-ЕР-24-01	Хувилбар №01 Мэдээллийн огноо: 2020.12.10,	ЖК-2-ЕР-24-01 Хувилбар №01 Мэдээллийн огноо: 2020.12.10, Анхан шатны боловсруулалт	Мэдээллийн аюулгүй байдлын журам Хуудас 19 / 21
---------------	--	--	--

### Хавсралт 3. Цахим шуудангийн гарын үсэг

ЦУС



СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

Овог НЭР  
Албан тушаал  
+976 - XXXXXX  
<http://donor.mohs.mn/>

**АНХААРУУЛГА:** Энэхүү и-мэйл болоод түүнд хавсаргасан мэдээлэл нь зөвхөн тодорхой хүлээн авагчид зориулагдсан бөгөөд хориотой мэдээллийг агуулсан байх магадлалтай. Хэрэв танд тус и-мэйл зориулагдаагүй бол хавсралтуудыг хувилах, гадагш задруулах нь хориотой юм. Иймд тус и-мэйл танд ямар нэгэн алдааны улмаас хүргэгдсэн бол ЦССТ-ийн [admin@donor.mohs.mn](mailto:admin@donor.mohs.mn) хаягаар болон илгээгч рүү и-мэйлээр эргэн мэдэгдэж, цахим шууданг даруй устгана уу. Баярлалаа.

### Хавсралт 4. Мэдээллийн системд хандах эрх авах хүсэлт

#### Мэдээллийн системд хандах эрх авах маягт

Тасгийн нэр: .....

Албан тушаал: .....

Овог, Нэр: .....

Эрх хүссэн системийн нэр: .....

Эрх ашиглах хугацаа: .....

Эрх авах хэрэгцээ шаардлага: .....

Хүсэлт гаргасан огноо: .....

Хүсэлт гаргасан .....

Хянасан .....

Зөвшөөрсөн .....

Эрх олгосон .....

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба				
Баримт бичгийн дугаар: Ж-2-ЕР-24-01	Мэдээллийн аюулгүй байдлын журам			
Хувилбар №01	Мэrdжэк эхэлсэн огноо: 2020.12.10	Өөрчлөлт Анхан шатны боловсруулалт	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо:	Хуудас 20 / 21

## Хавсралт 5. Зөөврийн хэрэгсэл ашиглах хүсэлт

### Зөөврийн хэрэгсэл ашиглах хүсэлтийн маягт

Тасгийн нэр: .....  
Албан тушаал: .....  
Овог, Нэр: .....  
Зөөврийн хэрэгслийн сериал дугаар: .....  
Зөөврийн хэрэгслийн өмчлөл: Хувийн / Байгууллагын  
Ашиглах хугацаа: .....  
Эрх авах хэрэгцээ шаардлага: .....  
Хүсэлт гаргасан огноо: .....  
Хүсэлт гаргасан .....  
Хянасан .....  
Зөвшөөрсөн .....  
Эрх олгосон .....

## Хавсралт 6. Мэдээллийн системийн шалгах хуудас

Д/д	Системийн нэр	2020/ .... / .... - 2020/ .... / ....					
1							
2							
3							

ШАЛГАСАН: ..... Мэдээллийн технологийн инженер

ХЯНАСАН: ..... ЭШМТА-ны дарга

## 7. ХОЛБОГДОХ МАТЕРИАЛ

- 7.1. Эрүүл мэндийн сайдын 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/396 тоот тушаал
- 7.2. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 04 дугаар сарын 22-ны өдрийн 140 тоот тушаал
- 7.3. ЦССҮТ-ийн Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын баримт бичиг
- 7.4. Цусны албаны мэдээллийн технологийн хөгжлийн бодлого /2019-2025/

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба  
Баримт бичгийн дугаар: Мэдээллийн аюулгүй байдлын журам  
ЖК-2-ЕР-24-01

Хувилбар №01	Мөрдөж эхэлсэн огноо: 2020.12.10	Өөрчлөлт Анхан шатны боловсруулалт	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо:	Хуудас 21 / 21
--------------	--	--	---	----------------

1920-1921  
1921-1922  
1922-1923  
1923-1924  
1924-1925  
1925-1926  
1926-1927  
1927-1928  
1928-1929  
1929-1930  
1930-1931  
1931-1932  
1932-1933  
1933-1934  
1934-1935  
1935-1936  
1936-1937  
1937-1938  
1938-1939  
1939-1940  
1940-1941  
1941-1942  
1942-1943  
1943-1944  
1944-1945  
1945-1946  
1946-1947  
1947-1948  
1948-1949  
1949-1950  
1950-1951  
1951-1952  
1952-1953  
1953-1954  
1954-1955  
1955-1956  
1956-1957  
1957-1958  
1958-1959  
1959-1960  
1960-1961  
1961-1962  
1962-1963  
1963-1964  
1964-1965  
1965-1966  
1966-1967  
1967-1968  
1968-1969  
1969-1970  
1970-1971  
1971-1972  
1972-1973  
1973-1974  
1974-1975  
1975-1976  
1976-1977  
1977-1978  
1978-1979  
1979-1980  
1980-1981  
1981-1982  
1982-1983  
1983-1984  
1984-1985  
1985-1986  
1986-1987  
1987-1988  
1988-1989  
1989-1990  
1990-1991  
1991-1992  
1992-1993  
1993-1994  
1994-1995  
1995-1996  
1996-1997  
1997-1998  
1998-1999  
1999-2000  
2000-2001  
2001-2002  
2002-2003  
2003-2004  
2004-2005  
2005-2006  
2006-2007  
2007-2008  
2008-2009  
2009-2010  
2010-2011  
2011-2012  
2012-2013  
2013-2014  
2014-2015  
2015-2016  
2016-2017  
2017-2018  
2018-2019  
2019-2020  
2020-2021  
2021-2022  
2022-2023  
2023-2024  
2024-2025  
2025-2026  
2026-2027  
2027-2028  
2028-2029  
2029-2030  
2030-2031  
2031-2032  
2032-2033  
2033-2034  
2034-2035  
2035-2036  
2036-2037  
2037-2038  
2038-2039  
2039-2040  
2040-2041  
2041-2042  
2042-2043  
2043-2044  
2044-2045  
2045-2046  
2046-2047  
2047-2048  
2048-2049  
2049-2050  
2050-2051  
2051-2052  
2052-2053  
2053-2054  
2054-2055  
2055-2056  
2056-2057  
2057-2058  
2058-2059  
2059-2060  
2060-2061  
2061-2062  
2062-2063  
2063-2064  
2064-2065  
2065-2066  
2066-2067  
2067-2068  
2068-2069  
2069-2070  
2070-2071  
2071-2072  
2072-2073  
2073-2074  
2074-2075  
2075-2076  
2076-2077  
2077-2078  
2078-2079  
2079-2080  
2080-2081  
2081-2082  
2082-2083  
2083-2084  
2084-2085  
2085-2086  
2086-2087  
2087-2088  
2088-2089  
2089-2090  
2090-2091  
2091-2092  
2092-2093  
2093-2094  
2094-2095  
2095-2096  
2096-2097  
2097-2098  
2098-2099  
2099-20100